



ДУГААР #9
2011 оны 10 сарын 28

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Та бүхэн сайхан амраад сургуульдаа буцаж ирсэнд баяртай байна. Лхагва гарагийн өглөө хичээлдээ дуу шуу болон ирж байгаа сурагчдыгаа харахад сайхан байлаа. Даваа, Мягмар гарагт манай багш нар мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан. Манай багш нар өөрсдөө эдгээр сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд сургалтанд хамрагдсан багш нар сургалтын талаар сэтгэгдэл өндөр байсан. Ирэх хавар Бангкок хотноо болох EARCOS-н семинарт илтгэл тавих багш нарыг шалгаруулах уралдаан болж багш Katherine McDermott ОУДС-ийг төлөөлж энэ хуралд илтгэл тавих боллоо.

Түрүүчийн 2 удаагийн Мэдээнд би та бүхэнд сургуулийн ойрын 5 жилийн стратеги төлөвлөгөө, боловсролын талаар тависан зорилтуудын талаар дэлгэрэнгүй мэдээлсэн. Энэ удаагийн мэдээнд би хоёр дахь зорилт болох Хүний Нөөцийг бэхжүүлж, Ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх зорилтуудын тухай товч мэдээлэл өгнө.

Бид сургуулийн эрхэм зорилго, эрхэмлэх зүйлс, боловсролын үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрсөн сайн багш нарыг ажилд шалгаруулж тогтвор суурьшилтай ажиллуулах зорилт тавин ажилладаг. ОУДС-ийн хувьд манай багш ажилтнууд бидний хамгийн үнэт өв байдаг бөгөөд сургуулийн өмнөө тависан зорилгыг амжилттай хэрэгжүүлэх гол тулгуур хүчин зүйлс болдог. Монгол орны өвөрмөц соёл заншил, баялаг өв уламжлал дээр тулгуурлан дэлхийн шилдэг боловсролыг сурагчиддаа эзэмшүүлэхэд бидэнд туршлагатай, чадварлаг багш, ажилтнууд, удирдлагын баг хамт олон зайлшгүй хэрэгтэй.



Ийм хамт олныг бүрдүүлэхэд бидэнд ажиллах таатай орчин, сайн цалин урамшуулал, мэргэжлээ дээшлүүлэх, мэргэжлийн тал дээр өсч өндийх боломжууд шаардагдах нь зайлшгүй.

Бид энэ зорилгодоо хүрэхийн тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:

- Сургуулийн эрхэм зорилго, үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхийн төлөө ажиллах чадварлаг багш нарыг ажилд шалгаруулж тогтвор суурьшилтай удаан хугацаагаар ажиллуулах төлөвлөгөө боловсруулах
- Хамт олны идэвх санаачлага, инновацийг дэмжиж урамшуулдаг ажлын таатай орчинг бүрдүүлэх
- Тогтвор суурьшилтай ажиллах Удирдлагын бүтэц залгамж халааг бүрдүүлэх
- Мэргэжил дээшлүүлэх сургалтыг дэмжсэн үнэлгээний систем боловсруулах

THE MEDIEE

The Weekly Newsletter of the International School of Ulaanbaatar



Бид өвлийн амралт хүртэлх энэ хугацаанд ажилтан шалгаруулж авах төлөвлөгөөгөө бэлэн болгож ирэх хичээлийн жилд шинээр хичнээн багш ажилд авахаа тодорхойлох болно. Бид багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг олон хэлбэрээр цаашид ч зохион байгуулах болно. Бүх багш ажилчид жил бүр мэргэжлээ дээшлүүлж өөрсдийгөө хөгжүүлэх зорилтуудыг тодорхойлдог. Бид багш нартаа Даваа гараг бүр 15:00-16:30 хооронд туслах багш нартай хамтран сургалтын төлөвлөгөөгөө боловсруулах цагийг гаргаж өгсөн. Багш нарт удирдах ажлын туршлага суулгах боломж олгон удахгүй шинээр “Community Liaison Coordinator” сонгон ажиллуулах гэж байна.

Ингэснээр ОУДС-ийг Улаанбаатарт байгаа болон бусад байгууллагуудтай холбож хамтын ажиллагааг дээшлүүлэх боломж нэмэгдэх болно. ОУДС-ийн Дэд Захирал Туул болон Удирдах Зөвлөлийн гишүүн Nalin нар хүний нөөцийг бэхжүүлж ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх бүлгийн ажлыг удирдан явуулж байна. Багш сонгон шалгаруулах, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар авч хэрэгжүүлэх тэдний ажлын тайлантай бид удахгүй танилцах болно.

Захирал Robert Stearns

СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭДЭЭЛЭЛ

Эрхэм Хүндэт Эцэг Эхчүүд ээ,

ОУДС-ийн эцэг эхийн зөвлөлийн Жилийн Ерөнхий Хуралдааныг 2011 оны 11 сарын 17-ны Пүрэв гарагт 19:00 цагаас Сургуулийн Удирдах Зөвлөл удирдан зохион байгуулна. (Дараагийн Мэдээнд дэлгэрэнгүй мэдээллийг та бүхэнд хүргэнэ)

ЖИЛИЙН ЕРӨНХИЙ ХУРАЛДААН - 2011 оны 11 сарын 17

18:00 Хөнгөн Зууш, хоол ОУДС-ийн кафетерияд
18:30 ОУДС-ийн санхүүгийн товч мэдээлэл – номын санд
19:00 Жилийн Ерөнхий Хуралдаан-Сургуулийн биеийн тамирын заланд

ОУДС-ийн эцэг эх бүр Жилийн Ерөнхий Хуралдаан дээр санал өгөх эрхтэй байдаг учраас та бүхнийг хуралдаа ирж оролцохыг уриалж байна. Жилийн Ерөнхий Хуралдаан дээр Сургуулийн Удирдах Зөвлөл болон Захирал Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, цаашид хийгдэх ажлын төлөвлөгөөний талаар та бүхэнд мэдээлэл хийнэ.

Мөн энэ хуралдааны үеэр Удирдах Зөвлөлд шинээр сонгогдох гишүүдийн сонгууль явагддаг. Удирдах Зөвлөлд сонгогдож ажиллах нь хүүхдүүдийн боловсрол, сургуулийн ирээдүйн төлөө үйлчлэх сайхан боломж байдаг. Энэ жил удирдах зөвлөлд нэлээд хэдэн гишүүний сул орон тоо байгаа.

Хэрвээ та бүхэн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгогдох хүсэлтэй бол shane.rosenthal@gmail.com хаягаар надтай болон depdirector@isumongolia.edu.mn хаягаар сургуулийн Дэд Захирал Арилдийн Туултай 11 сарын 10-ны дотор холбоо барина уу. Нэр дэвшигч бүр Жилийн Ерөнхий Хуралдаан дээр өөрийгөө танилцуулж үг хэлэх боломжтой.

ОУДС-ийн Удирдах Зөвлөлийн Дарга Shane Rosenthal

Эцэг эх Багш нарын Бүлгийн (ЭББ) Хурал

Эрхэм хүндэт эцэг эхчүүд ээ,

Та бүхнийг 11 сарын 1-ний Мягмар гарагт 15:00 цагт сургуулийн номын санд болох ЭББ-ийн хуралд хүрэлцэн ирэхийг урьж байна. Бид Олон Улсын 7 хоногийн үеэр зохиогдох олон үндэстний хоолны өдөрлөгт бэлтгэх талаар болон бусад асуудлуудыг хэлэлцэнэ. Та бүхнийг ирж хуралдаа оролцохыг урьж байна.

ЭББ-ийн Дарга Charlotte O'Connell

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Та бүхэн намрын амралтаараа гэр бүлээрээ сайхан амарсан гэдэгт би итгэлтэй байна. Манай волейболын баг тамирчид Бээжинд болж байгаа АСАМИС-ийн тэмцээнд оролцохоор явсан. Сурагчид маань хуучин найз нөхөдтэйгээ уулзаж тэмцээндээ амжилттай оролцоод удахгүй буцаж ирнэ. Дараагийн мэдээнд тэмцээний талаар дэлгэрэнгүй мэдээлэлийг та бүхэнд хүргэнэ.

Уламжлал ёсоор сурагчдын 1-р улирлын сурлагын дүн та бүхэнд удахгүй ирэх долоо хоногийн эхээр очно. Эцэг Эх Багш нарын хурал 11 сарын 9-ний Лхагва гарагт болно. Энэ талаарх мэдээллийг та бүхэн дараагийн хуудаснаас үзээрэй.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

ОУДС-ийн хувьд эцэг эх багш нарын хурал нь боловсролын хөтөлбөрийн нэг чухал салшгүй хэсэг байдаг. 11 сарын 9-ний Лхагва гарагт өглөөний 8:00 цагаас оройн 17:00 цаг хүртэл та бүхнийг хүрэлцэн ирж хүүхдийнхээ анги удирдсан багштай уулзаж тэдний сурлагын амжилт, зан байдлын төлөвшилтийн талаар мэдээлэл солилцохыг урьж байна. Энэ өдөр сурагчдын хичээл орохгүй.

Та бүхэн 10 сарын 31-ний Даваа гарагийн 15:00 цагаас өмнө сургуулийн ресепшин Халиунаатай 70160010 дугаарын утсаар холбогдож уулзалтын цагаа товлон уу. Таны хүссэн цагт уулзалт хийх боломжгүй бол энэ өдрийн бусад цагт уулзалтын цагийг товлон болохыг анхаарна уу.

Хурлын үеэр та зөвхөн ангийн багштай 20 минутын хугацаанд уулзах болно. Хэрвээ та мэргэжлийн багштай уулзах хүсэлтэй бол энэ тухайгаа утсаар цаг авахдаа бидэнд мэдэгдэнэ үү.

Та бүхэн энэ өдөр ирж хүүхдийнхээ сургалтын талаар бидэнтэй ярилцаарай. Би та бүхэнтэй уулзаж санал бодлыг тань сонсоход бэлэн байна. Та бүхэн надтай primaryhead@isumongolia.edu.mn хаягаар болон 70160010 дугаарын утсаар холбоо бариарай.

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД

| | |
|----------------|--|
| 11 сарын 1 | ЭББ-ийн хурал сургуулийн номын санд 15:00 |
| 11 сарын 9 | Эцэг Эх Багш нарын хурал 8:00-17:00 энэ өдөр хичээл орохгүй |
| 11 сарын 14-18 | Олон Улсын 7 хоног |
| 11 сарын 17 | Жилийн Ерөнхий Хуралдаан ОУДС-ийн бүх эцэг эхчүүд оролцоно. 18:00 Хөнгөн Зууш, хоол ОУДС-ийн кафетерияд 18:30 ОУДС-ийн санхүүгийн товч мэдээлэл –номын санд 19:00 Жилийн Ерөнхий Хуралдаан-Сургуулийн биеийн тамирын заланд |

ОУДС-ийн Эцэг Эх Багш нарын Хурал!

11 сарын 9-ний Пүрэв гарагийг та бүхэн
хуанлидаа тэмдэглээрэй.

Бага, Дунд сургуулийн бүх багш нар
8:00 – 17:00
цагт та нартай уулзахад бэлэн.

{Энэ өдөр хичээл орохгүй тул та бүхэн хурлын
товлосон цагт хүүхдээ дагуулж ирнэ үү}

**Та бүхэн цагаа зохицуулан
хуралдаа ирж оролцоорой!**